

МОНГОЛБАНКНЫ ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН ЖУРМЫН ТӨСӨЛ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү журмын зорилго нь Зээлийн мэдээллийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1-д заасан зээлийн мэдээллийн санг бүрдүүлэх, зээлийн мэдээллийг хадгалах, хамгаалах, ашиглах, мэдээлэл нийлүүлэгч, хэрэглэгчтэй мэдээлэл солилцох, мэдээллээр хангах гэрээ байгуулах болон зээлийн мэдээллийн үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах хүрээнд зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл авсан хуулийн этгээдийн үйл ажиллагаа хэвийн хангагдах, зээлийн мэдээллийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн, хүчингүй болгосон хугацаанд зээлийн мэдээллийн үйл ажиллагааг эрхлэх харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Монголбанкны зээлийн мэдээллийн сан нь энэхүү журмын 3 дугаар бүлэгт заасан мэдээллээс бүрдэнэ.
- 1.3. Монголбанкны зээлийн мэдээллийн сангийн үйл ажиллагаанд Зээлийн мэдээллийн тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан зарчмыг баримтална.

Хоёр. Монголбанкны зээлийн мэдээллийн сангийн үйл ажиллагаа

- 2.1. Монголбанкны зээлийн мэдээллийн сан нь хуанлийн өдрүүдэд 24 цаг ажиллана.
- 2.2. Монголбанкны Зээлийн мэдээллийн алба нь энэхүү журмын 1.1 заалтыг хангах зорилгоор зээлийн мэдээллийн сангийн үйл ажиллагааг эрхэлнэ.
- 2.3. Зээлийн мэдээллийн алба нь дараах эрхийг эдэлнэ:
 - 2.3.1. Мэдээлэл нийлүүлэгч, хэрэглэгчтэй энэхүү журмын 1, 2 дугаар хавсралтад дурдсан гэрээ байгуулах, татгалзах, хүчингүй болгох;
 - 2.3.2. Мэдээлэл нийлүүлэгч, хэрэглэгчийн Монголбанкны зээлийн мэдээллийн санд хандах эрхийг олгох, түдгэлзүүлэх, хаах, зохицуулах;
 - 2.3.3. Монголбанкны удирдлагаас өгсөн чиглэл, иргэд, аж ахуйн нэгжээс ирүүлсэн гомдол, өргөдлийн дагуу хэрэглэгч болон зээлийн мэдээлэлтэй холбоотой асуудлыг шийдвэрлэж хариу хүргүүлэх.
- 2.4. Зээлийн мэдээллийн алба нь дараах үүргийг хүлээнэ:
 - 2.4.1. Энэхүү журмын 3 дугаар бүлэгт заасан мэдээллийг цуглуулах замаар Монголбанкны Зээлийн мэдээллийн санг бүрдүүлэх;
 - 2.4.2. Зээлдэгчийн зээлийн мэдээллийн аюулгүй, найдвартай байдлыг хангах, шинэчлэх арга хэмжээ авах, хяналт тавих;

- 2.4.3. Зээлийн лавлагааг хэрэглэгч, мэдээлэл нийлүүлэгч, хууль, хяналтын болон төрийн байгууллагуудад гаргаж өгөх /шаардлагатай тохиолдолд утсаар болон цахим шуудангаар хүргүүлж болно/;
 - 2.4.4. Мэдээлэл нийлүүлэгчээс ирүүлсэн хүсэлтийг харгалзан зээлийн мэдээллийг засварлах, шаардлагатай тохиолдолд устгах арга хэмжээг энэхүү журамд заасан горимын дагуу авах;
 - 2.4.5. Монголбанкнаас албадлагын арга хэмжээ авч буй эрх бүхий этгээд, Хууль эрх зүйн газраас ирүүлсэн хүсэлтийн дагуу харгалзан зээлийн мэдээллийг засварлах, устгах;
 - 2.4.6. Тусгай зөвшөөрөл хүчингүй болсон эсхүл татан буугдсан мэдээлэл нийлүүлэгчээс нийлүүлсэн зээлийн мэдээллийг зохицуулагч байгууллагын тодорхойлолтыг үндэслэн засварлах, устгах арга хэмжээ авах;
 - 2.4.7. Шүүхийн шийдвэрийн дагуу зээлийн мэдээллийг засварлах, устгах;
 - 2.4.8. Санхүүгийн зуучлал, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар Зээлийн лавлагаанд шаардлагатай гэж үзсэн мэдээллийг тусгах, эс тусгах, мэдээлэлд өөрчлөлт оруулах арга хэмжээг Монголбанкны газар, нэгжтэй хамтран хэрэгжүүлэх;
 - 2.4.9. Авлага барагдуулах, хяналт шалгалт хийх болон бусад зорилгоор Монголбанкны газар, нэгжид зээлийн мэдээллийн санд хандах эрхийг олгох;
 - 2.4.10. Монголбанкны зээлийн мэдээллийн сангийн үйл ажиллагаатай холбоотой өргөдөл, гомдлыг шийдвэрлэх;
 - 2.4.11. Мэдээлэл нийлүүлэгч, хэрэглэгч нартай байгуулсан гэрээний хэрэгжилтэд хяналт тавих;
 - 2.4.12. Мэдээлэл нийлүүлэгч, хэрэглэгчийн гаргасан хүсэлтийн дагуу уулзалт хийх, санал солилцох, зөвлөгөө өгөх, сургалт зохион байгуулах;
 - 2.4.13. Зээлийн мэдээллийн сангийн үйл ажиллагааны талаар олон нийтийн ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх, харилцагчийн эрх ашгийг хамгаалах хүрээнд Монголбанкны газар, нэгж болон бусад байгууллагатай хамтран ажиллах;
 - 2.4.14. Монголбанкны газар, нэгжийн хүсэлтийн дагуу эдийн засаг, зах зээлийн судалгаа, дүн шинжилгээ хийх болон бусад зорилгоор зээлийн мэдээллийн сангийн холбогдох мэдээллийг гаргаж өгөх;
 - 2.4.15. Монголбанкны зээлийн мэдээллийн алба нь зээлийн мэдээллийн сангийн мэдээллийг үнэн зөв, бодит байдалд нийцүүлэх арга хэмжээг тогтмол авч ажиллах.
- 2.5. Мэдээллийн технологийн газар нь зээлийн мэдээллийн сангийн үйл ажиллагааны хүрээнд дараах үүргийг хүлээнэ:
- 2.5.1. Зээлийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах, нууцлалыг тогтмол сайжруулах, мэдээлэл алдагдахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

- 2.5.2.Зээлийн мэдээллийн сангийн програм хангамжийг өөрчлөх, хөгжүүлэх, програмд гарсан алдаа доголдлыг хурдан шуурхай засах, техник тоног төхөөрөмжийн найдвартай, тасралтгүй үйл ажиллагааг хангах;
- 2.5.3.Хэрэглэгч, мэдээлэл нийлүүлэгчтэй зээлийн мэдээлэл солилцох үйл ажиллагааг хангаж ажиллах;
- 2.5.4.Зээлийн мэдээллийн санд нийлүүлэгдсэн зээлийн мэдээллийн үнэн зөв, бодит байдлыг баталгаажуулах зорилгоор мэдээлэл нийлүүлэгчээс ирүүлсэн албан хүсэлтийн дагуу тухайн мэдээлэл нийлүүлэгчийн нийлүүлсэн зээлийн мэдээллийн тайланг гаргаж өгөх;
- 2.5.5.Зээлийн мэдээллийн албаны хүсэлтийн дагуу Зээлийн мэдээллийн сангийн мэдээлэлд өөрчлөлт оруулах, устгах;
- 2.5.6.Зээлийн мэдээллийн албаны хүсэлтийн дагуу зээлийн мэдээллийн сантай холбоотой мэдээллийг гаргаж өгөх, зээлийн мэдээллийн сангийн програм хангамж, өгөгдлийн санд нэмэлт өөрчлөлт оруулах, хөгжүүлэлт хийх;
- 2.5.7.Зээлийн мэдээллийн албанд шаардлагатай тохиолдолд хүний нөөц, мэргэжлийн болон техникийн туслалцаа үзүүлэх;
- 2.5.8.Хэрэглэгч, мэдээлэл нийлүүлэгч нарт зээлийн мэдээллийн сангийн програм ашиглалт, мэдээлэл нийлүүлэлттэй холбоотой асуудлаар зааварчилгаа, зөвлөгөө өгөх.
- 2.6.Хууль, эрх зүйн газар нь зээлийн мэдээллийн сангийн үйл ажиллагааны хүрээнд дараах үүргийг хүлээнэ:
- 2.6.1.Монголбанкнаас мэдээлэл нийлүүлэгч, хэрэглэгчтэй гэрээний төслийг хянах, хадгалах.
- 2.7.Орон нутаг дахь Монголбанкны хэлтэс, салбар нь зээлийн мэдээллийн санг ажлын хэрэгцээнд ашиглах эрхтэй бөгөөд шаардлагатай тохиолдолд зээлийн мэдээллийн сан хариуцсан нэгжээс өгсөн зөвлөмжийн дагуу иргэн, хуулийн этгээдэд зээлийн лавлагааг гаргаж өгч болно.

Гурав. Монголбанкны зээлийн мэдээллийн сангийн бүрдүүлэлт

- 3.1.Монголбанкны зээлийн мэдээллийн сан нь Зээлийн мэдээллийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-т заасан этгээдүүдээс нийлүүлсэн тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээлэл, авлага, банк, санхүүгийн байгууллагаас гаргасан баталгаа, батлан даалт, аккредитив, бусад хүлээж болзошгүй үүрэг болон Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар зээлийн мэдээлэлд хамруулах шаардлагатай гэж үзсэн бусад мэдээллээс бүрдэнэ.
- 3.2.Монголбанк болон мэдээлэл нийлүүлэгчийн хооронд байгуулсан гэрээний үндсэн дээр Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т заасан мэдээллийг нийлүүлнэ.
- 3.3.Зээлийн мэдээллийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан мэдээллийг Монголбанкны зээлийн мэдээллийн санд нийлүүлэхийг хориглоно.

Дөрөв. Монголбанкны зээлийн мэдээллийн сангийн мэдээллийг засварлах, устгах горим

- 4.1. Монголбанкны зээлийн мэдээллийн алба нь энэхүү журмын 2.4.14-т заасан арга хэмжээг шаардлагатай тохиолдолд Мэдээллийн технологийн газраар гүйцэтгүүлж болно.
- 4.2. Монголбанкны зээлийн мэдээллийн сангийн мэдээллийг засварлах, устгах хүсэлтийг дараах дарааллын дагуу шийдвэрлэнэ:
- 4.2.1. Хэрэглэгч, мэдээлэл нийлүүлэгч, зээлдэгчээс ирүүлсэн хүсэлт, холбогдох нотлох баримтыг зээлийн мэдээллийн тухай хууль тогтоомжийн дагуу хянан шалгаж, эсхүл шүүхийн шийдвэрийг үндэслэн Зээлийн мэдээллийн албаны хянан шалгагч холбогдох мэдээллийг засварлах, устгах хүсэлтийг үүсгэх;
 - 4.2.2. Мэдээллийг засварлах, устгахаар үүсгэсэн хүсэлтэд Зээлийн мэдээллийн албаны ахлах хянан шалгагч зээлийн мэдээллийн тухай хууль тогтоомжийн дагуу дараалсан хяналт тавих;
 - 4.2.3. Зээлийн мэдээллийн албаны дарга зээлийн мэдээллийн сангийн мэдээллийг засварлах, устгахаар үүсгэсэн хүсэлтийг шийдвэрлэх.

Тав. Монголбанкны зээлийн мэдээллийн сантай мэдээлэл солилцох, ашиглах хүсэлт, баримт бичгийг хянах, гэрээ байгуулах, татгалзах

- 5.1. Зээлийн мэдээллийн алба нь зөвхөн гэрээ байгуулсан этгээдтэй мэдээлэл солилцоно.
- 5.2. Банкинд энэхүү журмын 5.1 дэх заалт хамаарахгүй бөгөөд тус журмыг банк үйл ажиллагаандаа мөрдөн ажиллана.
- 5.3. Монголбанкны зээлийн мэдээллийн сантай мэдээлэл солилцох этгээд нь бичгээр хүсэлт гаргаж, энэхүү журмын 5.4-т заасан шаардлагыг хангасан тухай баримтын хамт ирүүлнэ.
- 5.4. Монголбанкны зээлийн мэдээллийн сантай мэдээлэл солилцох гэрээ байгуулахад мэдээлэл нийлүүлэгч, хэрэглэгчид тавигдах шаардлага:
- 5.4.1. Зээлийн мэдээлэл солилцоход шаардлагатай хүний нөөц, техник, тоног төхөөрөмж, програм хангамжаар хангагдсан байх;
 - 5.4.2. Үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй байх;
 - 5.4.3. Зээлийн мэдээллийн үйл ажиллагааг зохицуулсан дотоод дүрэм, журамтай байх;
 - 5.4.4. Зээлийн мэдээллийн сан хариуцсан ажилтны эрх үүрэг, хүлээх хариуцлагыг тодорхой тусгасан ажлын байрны тодорхойлолтыг баталсан байх;
 - 5.4.5. Гүйцэтгэх удирдлага болон зээлийн мэдээллийн сан хариуцсан ажилтны нууцын баталгааг ирүүлсэн байх;

- 5.5.Монголбанкны зээлийн мэдээллийн алба журмын 5.3-т заасан баримт бичгийг бүрэн гүйцэд хүлээн авсан өдрөөс хойш гуч (30) хоногийн дотор шийдвэрлэж, гэрээ байгуулна.
- 5.6.Зээлийн мэдээллийн алба нь дараах үндэслэлээр гэрээ байгуулахаас татгалзана:
- 5.6.1. Энэхүү журмын 5.3-т заасан шаардлагыг хангаагүй;
 - 5.6.2. Энэхүү журмын 5.2-т заасан баримтыг бүрэн гүйцэд ирүүлээгүй;
 - 5.6.3. Ирүүлсэн баримт бичиг нь хуурамч, бодит бус;
- 5.7.Зээлийн мэдээллийн алба нь гэрээ байгуулахаас татгалзсан тохиолдолд энэ тухай хүсэлт гаргагчид албан бичгээр мэдэгдэнэ.
- 5.8.Монголбанкнаас мэдээлэл нийлүүлэгч, хэрэглэгчтэй гэрээ байгуулахаас татгалзсан, гэрээг хүчингүй болгосноос хойш 3 сарын дараа дахин гэрээ байгуулах хүсэлт хүлээн авна.

Зургаа. Мэдээлэл нийлүүлэгч, хэрэглэгчийн эрх үүрэг

- 6.1.Мэдээлэл нийлүүлэгч, хэрэглэгч нь Зээлийн мэдээллийн тухай хуульд заасан эрхийг эдэлж, үүргийг хүлээнэ.
- 6.2.Мэдээлэл нийлүүлэгч, хэрэглэгч нь Зээлийн мэдээллийн тухай хууль зааснаас гадна дараах үүрэгтэй:
- 6.2.1.Зээлийн мэдээллийг засварлах, устгахтай холбоотой гаргасан зээлдэгчийн өргөдөл, гомдол, хүсэлтийг мэдээлэл нийлүүлэгч хүлээн авч, шийдвэрлэх бөгөөд хэрхэн шийдвэрлэсэн тухай хариуг зээлдэгчид хүргүүлэх;
 - 6.2.2.Иргэн, аж ахуйн нэгжийн анхны хүсэлтийн дагуу зээлийн лавлагааг гаргаж өгөх;
 - 6.2.3.Зээлийн мэдээллийн сан хариуцсан ажилтан өөрчлөгдөх тухай бүрт Зээлийн мэдээллийн албанд мэдэгдэх, зээлийн мэдээллийн нууцын баталгаа ирүүлэх;
 - 6.2.4.Монголбанкны зээлийн мэдээллийн албанаас шаардсан зээлдэгчтэй холбоотой мэдээлэл, баримт, материалыг заасан хугацаанд ирүүлэх;
 - 6.2.5. Зээлийн мэдээллийн сангийн үйл ажиллагааны талаар иргэн, аж ахуйн нэгжид үнэн зөв мэдээлэл, тайлбар өгөх, сургалт зохион байгуулах;
 - 6.2.6. Банк нь энэхүү журмын 5.3-т заасан шаардлагыг хангаж ажиллах.
- 6.3.Энэхүү журмын 6.2.2-т заасан зээлийн лавлагааг ашиг олох зорилгоор гаргаж өгөхийг хориглоно.
- 6.4.Мэдээлэл нийлүүлэгч, хэрэглэгчийн зээлийн мэдээллийн сан хариуцсан ажилтан нь зээлийн мэдээллийн сургалтад заавал хамрагдсан байна.

Долоо. Хяналт, хариуцлага

- 7.1.Зээлийн мэдээлэл солилцох, ашиглах гэрээг байгуулахаас татгалзсан, хүчингүй болгосон, Монголбанкны зээлийн мэдээллийн сангийн мэдээллийг ашиглан холбогдох шийдвэр гаргаснаас үүдсэн аливаа эрсдэл, хохирлыг Монголбанк хариуцахгүй.
- 7.2.Зээлийн мэдээллийн алба нь дараах үндэслэлээр гэрээг хүчингүй болгоно:

- 7.2.1. Энэхүү журмын 5.3-т заасан шаардлагыг хангаагүй;
 - 7.2.2. Хуурамч баримт бичиг бүрдүүлэн гэрээ байгуулсан;
 - 7.2.3. Эрх бүхий байгууллагаас олгосон тусгай зөвшөөрлийн хугацаа дуусгавар болсон, цуцлагдсан, хүчингүй болсон, татан буугдсан;
 - 7.2.4. Гэрээ байгуулснаас хойш мэдээлэл нийлүүлэгч нь 3 сарын хугацаанд Монголбанкны зээлийн мэдээллийн санд мэдээлэл нийлүүлээгүй;
 - 7.2.5. Хэрэглэгч нь Зээлийн мэдээллийн тухай хуулийн 10.1-т зааснаас өөр зорилгоор зээлийн мэдээллийг ашигласан;
 - 7.2.6. Мэдээлэл нийлүүлэгч нь Монголбанкны зээлийн мэдээллийн санд мэдээлэл нийлүүлэхдээ Зээлийн мэдээллийн тухай хуулийн 17.1-т заасан зарчмыг баримтлаагүй;
 - 7.2.7. Зээлийн мэдээллийн тухай хууль тогтоомжид заасан бусад заалтыг зөрчсөн;
- 7.3. Мэдээлэл нийлүүлэгч, хэрэглэгч нь энэхүү журмын 6.1, 6.2-т заасан үүргээ биелүүлээгүй бол сануулах, зөрчил давтагдвал зээлийн мэдээллийн санд хандах эрхийг тодорхой хугацаагаар хязгаарлах, эсхүл энэхүү журмын 7.2-т заасан үндэслэлээр арга хэмжээ авч болно.
- 7.4. Банкинд энэхүү журмын 7.3 дахь заалт хамаарахгүй бөгөөд тус журмыг зөрчсөн тохиолдолд Банкны тухай болон бусад хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.
- 7.5. Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд Зээлийн мэдээллийн тухай болон бусад хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

БАТЛАВ.

Монголбанкны Зээлийн
Мэдээллийн албаны дарга

.....
гүйцэтгэх захирал

.....
//

.....
//

МОНГОЛБАНКНЫ ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН САНД
ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЭЛ НИЙЛҮҮЛЭХ ГЭРЭЭ
Дугаар

..... оны дугаар сарын-ны өдөр

Улаанбаатар хот

Зээлийн мэдээллийн тухай хууль, Монголбанкны зээлийн мэдээллийн сангийн журмын холбогдох заалтуудыг үндэслэн нэг талаас Монголбанкны Зээлийн мэдээллийн алба, нөгөө талаас/улсын бүртгэлийн №....., регистр №/, /цаашид “Мэдээлэл нийлүүлэгч” гэх/ хооронд харилцан тохиролцсоны үндсэн дээр энэхүү гэрээг байгуулав.

НЭГ. Ерөнхий зүйл

1.1 Мэдээлэл нийлүүлэгч Зээлийн мэдээллийн тухай хуулийн 18.1-д заасан хугацаанд 28.2 дахь заалтын дагуу Монголбанкны зээлийн мэдээллийн журмын 3 дугаар бүлэгт заасан зээлийн мэдээллийг Монголбанкны зээлийн мэдээллийн санд нийлүүлэх, Зээлийн мэдээллийн алба мэдээлэл нийлүүлэгчээс нийлүүлсэн зээлийн мэдээллийг хүлээн авах, хадгалах, боловсруулах, нууцлал аюулгүй байдлыг хангах, бодит байдалтай нийцүүлэхийг шаардах, харилцан солилцоход энэхүү гэрээний зорилго оршино.

1.2 Талууд гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах эрхтэй. Нэмэлт, өөрчлөлт оруулах тухай саналыг гэрээнд оролцогч тал нь нөгөө талдаа бичгээр гаргаж, харилцан тохиролцсоны үндсэн дээр нэмэлт, өөрчлөлтийг оруулах бөгөөд энэхүү нэмэлт, өөрчлөлт нь гэрээний салшгүй хэсэг болно.

1.3 Мэдээлэл нийлүүлэгчийн Зээлийн мэдээллийн сан хариуцсан ажилтан албан тушаалтай овогтой нь Монголбанкны зээлийн мэдээллийн санд мэдээлэл нийлүүлэх эрх бүхий итгэмжлэгдсэн ажилтан болно.

ХОЁР. Монголбанкны эрх, үүрэг

2.1 Монголбанк Зээлийн мэдээллийн тухай хуульд зааснаас гадна дараах үүргийг хүлээнэ:

2.1.1. Монголбанкны зээлийн мэдээллийн сангийн журмын 3 дугаар бүлэгт заасан мэдээлэл нийлүүлэгчээс нийлүүлсэн зээлийн мэдээллийг Монголбанкны зээлийн мэдээллийн санд хуанлийн өдрүүдэд 24 цагийн хугацаанд хүлээн авах замаар Монголбанкны Зээлийн мэдээллийн санг бүрдүүлэх;

2.1.2. Зээлийн мэдээллийн санд нийлүүлсэн зээлийн мэдээллийн аюулгүй, найдвартай байдлыг хангах, хяналт тавих;

2.1.3. Зээлийн мэдээлэлтэй холбоотой зээлдэгч аж ахуйн нэгж, иргэдээс ирүүлсэн гомдол, өргөдлийг мэдээлэл нийлүүлэгчид хүргүүлэн шийдвэрлүүлэх, хяналт тавих;

- 2.1.4. Монголбанкны зээлийн мэдээллийн сангийн журамд заасан горимын дагуу Мэдээлэл нийлүүлэгчээс ирүүлсэн хүсэлтийг харгалзан зээлийн мэдээллийг засварлах, шаардлагатай тохиолдолд устгах арга хэмжээг авах, баримт материалын бүрдэлт хангалтгүй эсвэл хуурамч байх тохиолдолд хүсэлтийг хүлээн авахаас татгалзах;
 - 2.1.5. Тусгай зөвшөөрөл хүчингүй болсон эсхүл татан буугдсан мэдээлэл нийлүүлэгчээс нийлүүлсэн зээлийн мэдээллийг зохицуулагч байгууллагын тодорхойлолтыг үндэслэн засварлах, устгах арга хэмжээ авах;
 - 2.1.6. Шүүхийн шийдвэрийн дагуу мэдээлэл нийлүүлэгчээс Монголбанкны зээлийн мэдээллийн санд нийлүүлсэн зээлийн мэдээллийг засварлах, устгах;
 - 2.1.7. Мэдээлэл нийлүүлэгчийн гаргасан хүсэлтийн дагуу уулзалт хийх, санал солилцох, зөвлөгөө өгөх, сургалт зохион байгуулах;
 - 2.1.8. Зээлийн мэдээллийн сангийн үйл ажиллагааны талаар олон нийтийн ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх, харилцагчийн эрх ашгийг хамгаалах хүрээнд мэдээлэл нийлүүлэгчтэй хамтран ажиллах;
 - 2.1.9. Монголбанк нь зээлийн мэдээллийн сангийн мэдээллийг үнэн зөв, бодит байдалд нийцүүлэх арга хэмжээг авах;
 - 2.1.10. Зээлийн мэдээллийн сангийн програм хангамжийг өөрчлөх, хөгжүүлэх, програмд гарсан алдаа доголдлыг хурдан шуурхай засах, техник тоног төхөөрөмжийн найдвартай, тасралтгүй үйл ажиллагааг хангах;
 - 2.1.11. Шаардлагатай тохиолдолд мэдээлэл нийлүүлэгчээс ирүүлсэн хүсэлтийн дагуу Монголбанкны зээлийн мэдээллийн санд нийлүүлэгдсэн зээлийн мэдээллийн тайланг гарган, хүргүүлэх;
 - 2.1.12. Зээлийн мэдээллийн тухай хууль, Хувь хүний нууцын тухай хууль, Байгууллагын нууцын тухай хууль болон бусад хууль тогтоомжийг сахин биелүүлэхтэй холбоотой арга хэмжээг тухай бүр авах.
- 2.2. Монголбанк Зээлийн мэдээллийн тухай хуульд зааснаас гадна дараах эрхийг эдэлнэ:
- 2.2.1. Мэдээлэл нийлүүлэгчээс Монголбанкны зээлийн мэдээллийн санд нийлүүлсэн мэдээллийг Зээлийн мэдээллийн тухай хууль тогтоомжийг дагуу ашиглах;
 - 2.2.2. Зээлийн мэдээллийн тухай хууль тогтоомжид заасан зээлийн мэдээллийн шаардлагыг хангаагүй тохиолдолд нийцүүлэхийг шаардах;
 - 2.2.3. Зээлийн мэдээллийн тухай хууль тогтоомжийн дагуу зээлийн мэдээллийн үнэн бодит байдлыг хангуулах хүрээнд мэдээлэл нийлүүлэгчээс зээлдэгчтэй холбоотой нэмэлт мэдээлэл, баримт материал шаардан гаргуулж авах;
 - 2.2.4. Зээлийн мэдээлэлтэй холбоотой статистик мэдээлэл гаргуулан авах;
 - 2.2.5. Зээлийн мэдээллийн сангийн програм, техник тоног төхөөрөмжийг шинэчлэх хугацаанд зээлийн мэдээллийн үйл ажиллагааг тодорхой хугацаагаар зогсоох;
 - 2.2.6. Зээлийн мэдээллийн тухай хууль тогтоомж, энэхүү гэрээг зөрчсөн мэдээлэл нийлүүлэгчтэй байгуулсан гэрээг хүчингүй болгох, мэдээлэл авах, нийлүүлэх эрхийг түр хугацаагаар түдгэлзүүлэх.
 - 2.2.7. Зээлийн мэдээллийн тухай хууль тогтоомжийг мэдээлэл нийлүүлэгчээр дамжуулан олон нийтэд сурталчлах, сургалт зохион байгуулах;
 - 2.2.8. Санхүүгийн зуучлал, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар Зээлийн лавлагаанд шаардлагатай гэж үзсэн мэдээллийг тусгах, эс тусгах, мэдээлэлд өөрчлөлт оруулах арга хэмжээг;
 - 2.2.9. Энэхүү гэрээг нэг талын хүсэлтээр хүчингүй болгох.

ГУРАВ. Мэдээлэл нийлүүлэгчийн эрх, үүрэг

3.1 Мэдээлэл нийлүүлэгч нь дор дурдсан үүргийг хүлээнэ:

- 3.1.1. Мэдээлэл нийлүүлэгч нь Зээлийн мэдээллийн тухай хуульд заасан үүргийг;
- 3.1.2. Зээлийн мэдээллийн тухай хууль болон Монголбанкны зээлийн мэдээллийн сангийн журамд заасан мэдээллийг Монголбанкны зээлийн мэдээллийн санд нийлүүлэх;
- 3.1.3. Зээлийн мэдээллийн тухай хуулийн 18.1-д заасан хугацаанд зээлийн мэдээлэл нийлүүлэх, нийлүүлсэн мэдээлэлд өөрчлөлт оруулах;
- 3.1.4. Монголбанкны зээлийн мэдээллийн санд нийлүүлж буй зээлийн мэдээллийн (мэдээлэл, тоног төхөөрөмж, програм хангамж) нууцлал, аюулгүй байдлыг хангах;
- 3.1.5. Мэдээлэл нийлүүлэгч энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ байгалийн давагдашгүй хүчин зүйл болон бусад нөхцөл байдлаас шалгаалан гүйцэтгэх боломжгүй болсон тохиолдолд Монголбанкны зээлийн мэдээллийн албанд энэ талаар ажлын 5 хоногийн дотор мэдэгдэнэ.
- 3.1.6. Мэдээлэл нийлүүлэгчийн хуулийн этгээдийн хэлбэр, хаяг, удирдлага өөрчлөгдсөн тухай бүр Монголбанкны зээлийн мэдээллийн албанд мэдэгдэнэ.
- 3.1.7. Мэдээлэл нийлүүлэгч нь Зээлийн мэдээллийн тухай хууль зааснаас гадна дараах үүрэгтэй:
 - 3.1.7.1. Зээлийн мэдээллийг засварлах, устгахтай холбоотой гаргасан зээлдэгчийн өргөдөл, гомдол, хүсэлтийг мэдээлэл нийлүүлэгч хүлээн авч, шийдвэрлэх бөгөөд хэрхэн шийдвэрлэсэн тухай хариуг зээлдэгчид хүргүүлэх;
 - 3.1.7.2. Иргэн, аж ахуйн нэгжийн анхны хүсэлтийн дагуу зээлийн лавлагааг гаргаж өгөх;
 - 3.1.7.3. Зээлийн мэдээллийн сан хариуцсан ажилтан өөрчлөгдөх тухай бүрт Зээлийн мэдээллийн албанд мэдэгдэх, зээлийн мэдээллийн нууцын баталгаа ирүүлэх;
 - 3.1.7.4. Монголбанкны зээлийн мэдээллийн албанаас шаардсан зээлдэгчтэй холбоотой нэмэлт мэдээлэл, баримт, материалыг заасан хугацаанд, түргэн шуурхай ирүүлэх;
 - 3.1.7.5. Зээлийн мэдээллийн сангийн үйл ажиллагааны талаар иргэн, аж ахуйн нэгжид үнэн зөв мэдээлэл, тайлбар өгөх, сургалт зохион байгуулах;
- 3.1.8. Мэдээлэл нийлүүлэгч дараах шаардлагыг байнга хангаж ажиллана:
 - 3.1.8.1. Зээлийн мэдээлэл солилцоход шаардлагатай хүний нөөц, техник, тоног төхөөрөмж, програм хангамжаар хангагдсан байх;
 - 3.1.8.2. Үйл ажиллагааг эрхлэх тухай эрх бүхий этгээдийн шийдвэрийг авсан байх;
 - 3.1.8.3. Зээлийн мэдээллийн сан хариуцсан ажилтны эрх үүрэг, хүлээх хариуцлагыг тодорхой тусгасан ажлын байрны тодорхойлолтыг баталж, мөрдүүлэх;
 - 3.1.8.4. Гүйцэтгэх удирдлага болон зээлийн мэдээллийн сан хариуцсан ажилтны Монголбанкинд гаргасан зээлийн мэдээллийн нууцын баталгааг тухай бүр шинэчлэн ирүүлэх.
- 3.1.9. Монголбанкны зээлийн мэдээллийн сангийн лавлагааг ашиг олох зорилгоор гаргаж өгөхийг хориглоно.

3.1.10. Мэдээлэл нийлүүлэгчийн зээлийн мэдээллийн сан хариуцсан ажилтан нь зээлийн мэдээллийн сургалтанд заавал хамрагдсан байна.

3.2. Мэдээлэл нийлүүлэгч нь дор дурдсан эрхийг эдэлнэ:

3.2.1. Мэдээлэл нийлүүлэгч нь Зээлийн мэдээллийн тухай хуульд заасан эрхийг;

3.2.2. Энэхүү гэрээг нэг талын хүсэлтээр хүчингүй болгох.

ДӨРӨВ. Хариуцлага

4.1 Энэ гэрээний дагуу олж авсан мэдээллийг гэрээнд заасан зориулалтаас өөр бусад зорилгоор ашигласан, бусдад аливаа хэлбэрээр задруулсан, задруулах нөхцөлийг бүрдүүлэхийг талуудад хориглоно.

4.2 Мэдээлэл нийлүүлэгч нь энэ гэрээний 4.1-т дурдсан үйлдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор мэдээллийн нууцлалыг хадгалах, мэдээллийг дамжуулах, хүлээн авах, боловсруулах зэрэг тухайн мэдээлэлд нэвтрэх эрх бүхий этгээд, ажилтнуудын үйл ажиллагаа, хариуцлагыг тодорхой зохицуулсан заавар, журмыг баталж, мөрдөж ажиллана. Тус заавар, журмын нэг хувийг гэрээ байгуулснаас хойш ажлын 10 хоногийн дотор Монголбанкны Зээлийн мэдээллийн албанд хүргүүлнэ.

4.3 Энэ гэрээний 4.1-т дурдсан нэг талын үйлдэл нь Эрүүгийн болон холбогдох бусад хууль тогтоомж зөрчсөн байж болзошгүй тохиолдолд энэ талаар зохих эрх бүхий байгууллагад гэрээний нөгөө тал шуурхай мэдээлнэ.

4.4 Монголбанкны зээлийн мэдээллийн алба нь энэ гэрээний 4.2-т дурдсан заавар, журмын хувийг гэрээний 4.3-т заасан тохиолдол үүсмэгц эрх бүхий байгууллагад шалгуулахаар шилжүүлэх эрхтэй.

4.5 Энэ гэрээг зөрчсөний улмаас бусдад учирсан аливаа хохирлыг тухайн зөрчлийг гаргасан тал бүрэн хариуцна.

4.6 Зээлийн мэдээлэл солилцох, ашиглах гэрээг байгуулахаас татгалзсан, хүчингүй болгосон, Монголбанкны зээлийн мэдээллийн сангийн мэдээллийг ашиглан холбогдох шийдвэр гаргаснаас үүдсэн аливаа эрсдэл, хохирлыг Монголбанк хариуцахгүй.

4.7 Зээлийн мэдээллийн алба нь дараах үндэслэлээр гэрээг хүчингүй болгоно:

4.7.1. Монголбанкны зээлийн мэдээллийн сангийн журмын 5.3-т заасан шаардлагыг хангаагүй;

4.7.2. Хуурамч баримт бичиг бүрдүүлэн гэрээ байгуулсан;

4.7.3. Эрх бүхий байгууллагаас олгосон тусгай зөвшөөрлийн хугацаа дуусгавар болсон, цуцлагдсан, хүчингүй болсон, татан буугдсан;

4.7.4. Гэрээ байгуулснаас хойш мэдээлэл нийлүүлэгч нь 3 сарын хугацаанд Монголбанкны зээлийн мэдээллийн санд мэдээлэл нийлүүлээгүй;

4.7.5. Мэдээлэл нийлүүлэгч нь Монголбанкны зээлийн мэдээллийн санд мэдээлэл нийлүүлэхдээ Зээлийн мэдээллийн тухай хуулийн 17.1-т заасан зарчмыг баримтлаагүй;

4.7.6. Зээлийн мэдээллийн тухай хууль тогтоомжид заасан бусад заалтыг зөрчсөн.

4.7.7. Энэхүү гэрээний 4.8 дахь хэсгийн дагуу.

4.8 Мэдээлэл нийлүүлэгч нь Монголбанкны зээлийн мэдээллийн сангийн журмын 6.1, 6.2-т заасан болон энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд дараах арга хэмжээг авна:

- 4.8.1. Мэдээлэл нийлүүлэгчид сануулга хүргүүлэх;
- 4.8.2. Хэрвээ Монголбанкны зээлийн мэдээллийн санг ашиглах гэрээ байгуулсан бол ашиглах эрхийг 6 сар хүртэлх хугацаагаар түдгэлзүүлэх;
- 4.8.3. Монголбанкны зээлийн мэдээллийн сангийн лавлагаа авах эрхийг 3 сар хүртэлх хугацаагаар түдгэлзүүлэх;
- 4.8.4. Монголбанкны зээлийн мэдээллийн албаны зүгээс мэдээлэл нийлүүлэгчтэй байгуулсан гэрээг хүчингүй болгох.

ТАВ. Бусад зүйл

- 5.1 Энэхүү гэрээ нь талууд гарын үсэг зурж, тамга дарснаар хүчин төгөлдөр болно.
- 5.2 Мэдээлэл нийлүүлэгчийн мэдээлэл нийлүүлэх эрх бүхий ажилтан нь гэрээний хавсралтын дагуу нууцлалын баталгаа гаргаж Монголбанкны зээлийн мэдээллийн албанд ирүүлнэ.
- 5.3 Гэрээг 2 /хоёр/ хувь үйлдэх бөгөөд хувь тус бүр нь хуулийн дагуу адил хүчин төгөлдөр байна.
- 5.4 Энэхүү гэрээгээр зохицуулаагүй харилцаа болон гэрээтэй холбоотой маргааныг харилцан тохиролцох замаар шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд харилцан тохиролцоонд хүрээгүй тохиолдолд Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

ТАЛУУДЫГ ТӨЛӨӨЛЖ:

Монголбанкны Зээлийн мэдээллийн албаны дарга	
.....	
/ С.Ганбаяр /	/ /

Монголбанкны Зээлийн мэдээллийн албаны ажилтан	Итгэмжлэгдсэн эрх бүхий ажилтан
---	------------------------------------

.....	
/ Б.Азжаргал /	/ /

..... оны сарын өдрийн тоот
Хамтын ажиллагааны гэрээний хавсралт

НУУЦЫН БАТАЛГАА

Нууцын баталгаа гаргаж буй ажилтны

1.Байгууллагын албан ёсны нэр :

2.Эрхэлж буй албан тушаалын нэр :

3.Регистрийн дугаар :

4.Утасны дугаар :

5.Цахим хаяг:

6.Байгууллагын захирлын нэр, утасны дугаар:

_____ны _____миний бие албан үүргийн дагуу иргэд, аж ахуйн нэгжийн зээлийн мэдээллийн мэдээллийг Монголбанкны зээлийн мэдээллийн санд нийлүүлэхдээ нууцлалыг чанд хадгалж, хамгаалахаа баталж байна. Хэрэв би Зээлийн мэдээллийн тухай хууль тогтоомжийг зөрчин иргэн, аж ахуйн нэгжийн зээл, тэдгээртэй холбоотой бусад мэдээлийн нууцыг задруулснаас үүдэн бусдын эрх ашгийг хөндөж, ямар нэг байдлаар хохирол учруулбал Монгол Улсын Эрүүгийн болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээх болно.

БАТАЛГАА ГАРГАСАН

(гарын үсэг)

БАТАЛГАА ГАРГУУЛСАН:

(гарын үсэг)

/Байгууллагын тэмдэгээ дарна уу/

Баталгаа гаргуулсан албан тушаалтны:

Эцгийн болон өөрийн нэр

Албан тушаалын нэр

Ажлын болон гар утасны дугаар

..... оны сарын өдөр

БАТЛАВ.

Монголбанкны Зээлийн
Мэдээллийн албаны дарга

.....
гүйцэтгэх захирал

.....
//

.....
//

МОНГОЛБАНКНЫ ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН САНГ
АШИГЛАХ ГЭРЭЭ

Дугаар

..... оны дугаар сарын-ны өдөр

Улаанбаатар хот

Зээлийн мэдээллийн тухай хууль, Монголбанкны зээлийн мэдээллийн сангийн журмын холбогдох заалтуудыг үндэслэн нэг талаас Монголбанкны Зээлийн мэдээллийн алба, нөгөө талаас/ улсын бүртгэлийн №....., регистр №/, /цаашид “Хэрэглэгч” гэх/ хооронд харилцан тохиролцсоны үндсэн дээр энэхүү гэрээг байгуулав.

НЭГ. Ерөнхий зүйл

1.1 Монголбанкны зээлийн мэдээллийн сангийн зээлийн мэдээллийг Зээлийн мэдээллийн тухай хуулийн 10.1 дэх хэсэгт заасан зорилгоор хэрэглэгчид ашиглуулахтай холбоотой харилцааг зохицуулахад энэхүү гэрээний зорилго оршино.

1.2 Талууд гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах эрхтэй. Нэмэлт, өөрчлөлт оруулах тухай саналыг гэрээнд оролцогч тал нь нөгөө талдаа бичгээр гаргаж, харилцан тохиролцсоны үндсэн дээр нэмэлт, өөрчлөлтийг оруулах бөгөөд энэхүү нэмэлт, өөрчлөлт нь гэрээний салшгүй хэсэг болно.

1.3 Хэрэглэгчийн ажилтан албан тушаалтай овогтой нь Монголбанкны зээлийн мэдээллийн сангийн мэдээллийг ашиглах эрх бүхий итгэмжлэгдсэн ажилтан болно.

ХОЁР. Монголбанкны эрх, үүрэг

2.1 Монголбанк Зээлийн мэдээллийн тухай хуульд зааснаас гадна дараах үүргийг хүлээнэ:

- 2.1.1. Монголбанкны зээлийн мэдээллийн сангийн мэдээллийг хуанлийн өдрүүдэд 24 цагийн хугацаанд ашиглуулах;
- 2.1.2. Зээлийн мэдээллийн сангийн нууцлал, аюулгүй байдал, найдвартай ажиллагааг хангах;
- 2.1.3. Зээлийн мэдээлэлтэй холбоотой хэрэглэгчээс ирүүлсэн гомдол, өргөдлийг мэдээлэл нийлүүлэгчид хүргүүлэн шийдвэрлүүлэх, хяналт тавих;
- 2.1.4. Хэрэглэгч үнэн, бодит байдалтай нийцэхгүй зээлийн мэдээллийг илрүүлсэн тохиолдолд зээлийн мэдээллийг засварлах, шаардлагатай тохиолдолд устгах арга хэмжээг Монголбанкны зээлийн мэдээллийн сангийн журамд заасан горимын дагуу авах;
- 2.1.5. Хэрэглэгчийн гаргасан хүсэлтийн дагуу уулзалт хийх, санал солилцох, зөвлөгөө өгөх, сургалт зохион байгуулах;
- 2.1.6. Зээлийн мэдээллийн сангийн үйл ажиллагааны талаар олон нийтийн ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх, харилцагчийн эрх ашгийг хамгаалах хүрээнд хэрэглэгчтэй хамтран ажиллах;

- 2.1.7. Зээлийн мэдээллийн сангийн програм хангамжийг өөрчлөх, хөгжүүлэх, програмд гарсан алдаа доголдлыг хурдан шуурхай засах, техник тоног төхөөрөмжийн найдвартай, тасралтгүй үйл ажиллагааг хангах;
- 2.1.8. Зээлийн мэдээллийн тухай хууль, Хувь хүний нууцын тухай хууль, Байгууллагын нууцын тухай хууль болон бусад хууль тогтоомжийг сахин биелүүлэхтэй холбоотой арга хэмжээг тухай бүр авах.
- 2.2. Монголбанк Зээлийн мэдээллийн тухай хуульд зааснаас гадна дараах эрхийг эдэлнэ:
- 2.2.1. Зээлийн мэдээллийг Зээлийн мэдээллийн тухай хууль тогтоомжийн дагуу ашиглаагүй гэж үзвэл хэрэглэгчээс зээлийн мэдээллийг ашиглалттай холбоотой мэдээлэл, баримт материалыг гаргуулан авах;
- 2.2.2. Зээлийн мэдээллийн ашиглалттай холбоотой статистик мэдээлэл гаргуулан авах;
- 2.2.3. Зээлийн мэдээллийн сангийн програм, техник тоног төхөөрөмжийг шинэчлэх хугацаанд зээлийн мэдээллийн үйл ажиллагааг тодорхой хугацаагаар зогсоох;
- 2.2.4. Зээлийн мэдээллийн тухай хууль тогтоомж, энэхүү гэрээг зөрчсөн хэрэгтэгчтэй байгуулсан гэрээг хүчингүй болгох, мэдээлэл ашиглах эрхийг түр хугацаанд зохицуулах, түдгэлзүүлэх.
- 2.2.5. Зээлийн мэдээллийн тухай хууль тогтоомжийг хэрэглэгчээр дамжуулан олон нийтэд сурталчлах, сургалт зохион байгуулах;
- 2.2.6. Санхүүгийн зуучлал, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар Зээлийн лавлагаанд шаардлагатай гэж үзсэн мэдээллийг тусгах, эс тусгах, мэдээлэлд өөрчлөлт оруулах арга хэмжээг;
- 2.2.7. Энэхүү гэрээг нэг талын хүсэлтээр хүчингүй болгох.

ГУРАВ. Хэрэглэгчийн эрх, үүрэг

- 3.1 Мэдээлэл хэрэглэгч нь дор дурдсан үүргийг хүлээнэ:
- 3.1.1. Хэрэглэгч нь Зээлийн мэдээллийн тухай хуульд заасан үүргийг;
- 3.1.2. Зээлийн мэдээллийн тухай хууль тогтоомжид заасны дагуу Монголбанкны зээлийн мэдээллийн санг ашиглах;
- 3.1.3. Монголбанкны зээлийн мэдээллийн сангийн нууцлал, аюулгүй байдлыг хангах;
- 3.1.4. Хэрэглэгчийн хуулийн этгээдийн хэлбэр, хаяг, удирдлага өөрчлөгдсөн тухай бүр Монголбанкны зээлийн мэдээллийн албанд мэдэгдэнэ.
- 3.1.5. Хэрэглэгч нь Зээлийн мэдээллийн тухай хууль зааснаас гадна дараах үүрэгтэй:
- 3.1.5.1. Үнэн, бодит байдалтай нийцэхгүй зээлийн мэдээллийн талаар Монголбанкны Зээлийн мэдээллийн албанд мэдэгдэх;
- 3.1.5.2. Иргэн, аж ахуйн нэгжийн анхны хүсэлтийн дагуу зээлийн лавлагааг гаргаж өгөх;
- 3.1.5.3. Зээлийн мэдээллийн сан хариуцсан ажилтан өөрчлөгдөх тухай бүрт Зээлийн мэдээллийн албанд мэдэгдэх, зээлийн мэдээллийн нууцын баталгаа ирүүлэх;
- 3.1.5.4. Монголбанкны зээлийн мэдээллийн албанаас шаардсан зээлийн мэдээллийн ашиглалттай холбоотой статистик мэдээлэл, баримт, материалыг заасан хугацаанд, түргэн шуурхай ирүүлэх;
- 3.1.5.5. Зээлийн мэдээллийн сангийн үйл ажиллагааны талаар иргэн, аж ахуйн нэгжид үнэн зөв мэдээлэл, тайлбар өгөх, сургалт зохион байгуулах;
- 3.1.6. Хэрэглэгч дараах шаардлагыг байнга хангаж ажиллана:

- 3.1.6.1. Зээлийн мэдээллийг ашиглах үйл ажиллагааг зохицуулсан дотоод дүрэм, журамтай баталж, мөрдүүлэх;
 - 3.1.6.2. Зээлийн мэдээллийн сан хариуцсан ажилтны эрх үүрэг, хүлээх хариуцлагыг тодорхой тусгасан ажлын байрны тодорхойлолтыг баталж, мөрдүүлэх;
 - 3.1.6.3. Гүйцэтгэх удирдлага болон зээлийн мэдээллийн сан хариуцсан ажилтны Монголбанкинд гаргасан зээлийн мэдээллийн нууцын баталгааг тухай бүр шинэчлэн ирүүлэх.
- 3.1.7. Монголбанкны зээлийн мэдээллийн сангийн журмын 6.2.2-т заасан зээлийн лавлагааг ашиг олох зорилгоор гаргаж өгөхийг хориглоно.

3.2. Хэрэглэгч нь дор дурдсан эрхийг эдэлнэ:

- 3.2.1. Хэрэглэгч нь Зээлийн мэдээллийн тухай хуульд заасан эрхийг;
- 3.2.2. Энэхүү гэрээг нэг талын хүсэлтээр хүчингүй болгох.

ДӨРӨВ. Хариуцлага

- 4.1 Энэ гэрээний дагуу олж авсан мэдээллийг гэрээнд заасан зориулалтаас өөр бусад зорилгоор ашигласан, бусдад аливаа хэлбэрээр зээлийн мэдээллийг задруулахыг талуудад хориглоно.
- 4.2 Хэрэглэгч нь энэхүү гэрээний 4.1-т дурдсан үйлдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор мэдээллийн нууцлалыг хадгалах, мэдээллийг дамжуулах, хүлээн авах, боловсруулах зэрэг тухайн Зээлийн мэдээллийн санд нэвтрэх эрх бүхий этгээд, ажилтнуудын үйл ажиллагаа, хариуцлагыг тодорхой зохицуулсан заавар, журмыг баталж, мөрдөж ажиллана. Энэ заавар, журмын нэг хувийг гэрээ байгуулснаас хойш ажлын 10 хоногийн дотор Монголбанкны Зээлийн мэдээллийн албанд хүргүүлнэ.
- 4.3 Энэхүү гэрээний 4.1-т дурдсан нэг талын үйлдэл нь Эрүүгийн болон холбогдох бусад хууль тогтоомж зөрчсөн байж болзошгүй тохиолдолд энэ талаар зохих эрх бүхий байгууллагад гэрээний нөгөө тал шуурхай мэдээлнэ.
- 4.4 Монголбанкны зээлийн мэдээллийн алба нь энэхүү гэрээний 4.2-т дурдсан заавар, журмын хувийг гэрээний 4.3-т заасан тохиолдол үүсмэгц эрх бүхий байгууллагад шалгуулахаар шилжүүлэх эрхтэй.
- 4.5 Энэхүү гэрээг зөрчсөний улмаас бусдад учирсан аливаа хохирлыг хэрэглэгч бүрэн хариуцна.
- 4.6 Зээлийн мэдээллийн алба нь дараах үндэслэлээр гэрээг хүчингүй болгоно:
- 4.7.1. Монголбанкны зээлийн мэдээллийн сангийн журмын 5.2-т заасан шаардлагыг хангаагүй;
 - 4.7.2. Хуурамч баримт бичиг бүрдүүлэн гэрээ байгуулсан;
 - 4.7.3. Эрх бүхий байгууллагаас олгосон тусгай зөвшөөрлийн хугацаа дуусгавар болсон, цуцлагдсан, хүчингүй болсон, татан буугдсан;
 - 4.7.4. Хэрэглэгч нь Зээлийн мэдээллийн тухай хуулийн 10.1-т зааснаас өөр зорилгоор зээлийн мэдээллийг ашигласан нь тогтоогдсон;
 - 4.7.5. Зээлийн мэдээллийн тухай хууль тогтоомжид заасан бусад заалтыг зөрчсөн;
 - 4.7.6. Энэхүү гэрээний 4.8 дахь хэсгийн дагуу.

4.7 Хэрэглэгч нь Монголбанкны зээлийн мэдээллийн сангийн журмын 6.1, 6.2-т заасан болон энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд дараах арга хэмжээг авна:

4.8.1. Хэрэглэгчид сануулга хүргүүлэх;

4.8.2. Монголбанкны зээлийн мэдээллийн санг ашиглах эрхийг 6 сар хүртэлх хугацаагаар түдгэлзүүлэх;

4.8.3. Монголбанкны зээлийн мэдээллийн албаны зүгээс хэрэглэгчтэй байгуулсан гэрээг хүчингүй болгох.

ТАВ. Бусад зүйл

5.1 Энэхүү гэрээ нь талууд гарын үсэг зурж, тамга дарснаар хүчин төгөлдөр болно.

5.2 Хэрэглэгчийн мэдээлэл нийлүүлэх эрх бүхий ажилтан нь гэрээний хавсралтын дагуу нууцлалын баталгаа гаргаж Монголбанкны зээлийн мэдээллийн албанд ирүүлнэ.

5.3 Гэрээг 2 /хоёр/ хувь үйлдэх бөгөөд хувь тус бүр нь хуулийн дагуу адил хүчин төгөлдөр байна.

5.4 Энэхүү гэрээгээр зохицуулаагүй харилцаа болон гэрээтэй холбоотой маргааныг харилцан тохиролцох замаар шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд харилцан тохиролцоонд хүрээгүй тохиолдолд Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

ТАЛУУДЫГ ТӨЛӨӨЛЖ:

Монголбанкны Зээлийн мэдээллийн
албаны дарга

.....
/ С.Ганбаяр /

.....

.....
/ /

Монголбанкны Зээлийн
мэдээллийн албаны ажилтан

.....
/ Б.Азжаргал /

Итгэмжлэгдсэн эрх
бүхий ажилтан

.....
/ /

..... оны сарын өдрийн тоот
Хамтын ажиллагааны гэрээний хавсралт

НУУЦЫН БАТАЛГАА

Нууцын баталгаа гаргаж буй ажилтны

1.Байгууллагын албан ёсны нэр :

2.Эрхэлж буй албан тушаалын нэр :

3.Регистрийн дугаар :

4.Утасны дугаар :

5.Цахим хаяг:

6.Байгууллагын захирлын нэр, утасны дугаар:

_____ны _____миний бие албан үүргийн дагуу олж авсан иргэд, аж ахуйн нэгжийн зээлийн мэдээллийн нууцлалыг чанд хадгалж, хамгаалахаа баталж байна. Хэрэв би Зээлийн мэдээллийн тухай хууль, тогтоомжийг зөрчин иргэн, аж ахуйн нэгжийн зээл, тэдгээртэй холбоотой бусад мэдээллийн нууцыг алдаж үрэгдүүлэх эсвэл задруулснаас үүдэн бусдын эрх ашгийг хөндөж, ямар нэг байдлаар хохирол учруулбал Монгол Улсын Эрүүгийн болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээх болно.

БАТАЛГАА ГАРГАСАН

(гарын үсэг)

БАТАЛГАА ГАРГУУЛСАН:

(гарын үсэг)

/Байгууллагын тэмдэгээ дарна уу/

Баталгаа гаргуулсан албан тушаалтны:

Эцгийн болон өөрийн нэр

Албан тушаалын нэр

Ажлын болон гар утасны дугаар

..... ОНЫ сарын өдөр